

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, тодорхой газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, тур оператор болон тур агент, жуулчны хөтөчийн талаарх харилцааг шинэ түвшинд гаргах, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд албан журмаар даатгуулах замаар хариуцлагыг нэмэгдүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагыг төрөөс бодлогоор дэмжих, аялал жуулчлалын салбарт олон улсын жишгийг нэвтрүүлэх, хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг батлагдсан маршрутаар тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэх, аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын болон олон улсын холбогдох стандартын шаардлагыг ханган ажиллах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох, жуулчдын худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох, жуулчны татвар бий болгох зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлж, чадавхжуулах нөхцөл бүрдэх, аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бүрдэж, аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн удирдлагын дийлэнх олонхыг олон нийтийн төлөөлөл хэрэгжүүлэх, зарцуулалтад тавих хяналтыг төр, олон нийтийн төлөөлөл хамтран хэрэгжүүлэх, тусгай зориулалтын агнуурын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжих, гадаадын жуулчны виз олголтыг хөнгөвчлөх, хурдан шуурхай болгох, визгүй зорчих орны тоог нэмэгдүүлэх боломж бий болох, Монгол Улсыг зорин ирэх жуулчны тоо нэмэгдэнэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа жишиг аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялах чиглэлийг тогтоож, тодорхой болгох, энэ чиглэлээр мэргэшсэн олон улсын зөвлөх ажиллуулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ жуулчдыг аялах таатай орчныг бүрдүүлж, жуулчны визний асуудлыг хөнгөвчлөх, зорчигч тээврийн зардал, үйлчилгээг оновчтой болгоход анхаарах, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг стандартын шаардлага хангасан

ариун цэврийн байгууламжтай болоход анхаарах, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг аялал жуулчлалын маршрутыг Засгийн газраас тогтоодог болох, агаарын тээврийн үндэсний авиа компаниудаа бодлогоор дэмжих гэсэн саналуудыг хэлсэн болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аялал жуулчлалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ